**“ТАЛЫН МЕТАЛ НУНТАГ” ХХК**

**Металл боловсруулах бичил үйлдвэр**

# Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

**Улаанбаатар**

**2022 он**

# БАЯНГОЛ ДҮҮРГИЙН 20-Р ХОРООНЫ НУТАГТ БАЙРЛАХ

# “ТАЛЫН МЕТАЛ НУНТАГ” МЕТАЛЛ БОЛОВСРУУЛАХ БИЧИЛ ҮЙЛДВЭРИЙН 2022 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

/АЖ АХУЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ДУГААР:383/

/АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР: 6247814/

ХЯНАСАН: ............................................................../Ж.БАТЗОЛБОО/

НБОГ-ЫН ХБОБНХ-ИЙН МЭРГЭЖИЛТЭН

БОЛОВСРУУЛСАН: ................................................/Г.АНХБАТ/

“ТАЛЫН МЕТАЛ НУНТАГ” ХХК-ИЙН ТӨСЛИЙН ЗОХИЦУУЛАГЧ

УЛААНБААТАР ХОТ ТАЛЫН МЕТАЛ НУНТАГ ХХК 6247814 1117253222

# БАЯНГОЛ ДҮҮРГИЙН 20-Р ХОРООНЫ НУТАГТ БАЙРЛАХ

# “ТАЛЫН МЕТАЛ НУНТАГ” МЕТАЛЛ БОЛОВСРУУЛАХ БИЧИЛ ҮЙЛДВЭРИЙН 2022 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

/АЖ АХУЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ДУГААР:383/

/АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР: 6247814/

ХЯНАСАН: ............................................................../Ж.БАТЗОЛБОО/

НБОГ-ЫН ХБОБНХ-ИЙН МЭРГЭЖИЛТЭН

БОЛОВСРУУЛСАН: ....................................../Г.АНХБАТ/

“ТАЛЫН МЕТАЛ НУНТАГ” ХХК-ИЙН ТӨСЛИЙН ЗОХИЦУУЛАГЧ

# БАЯНГОЛ ДҮҮРГИЙН 20-Р ХОРООНЫ НУТАГТ БАЙРЛАХ

# “ТАЛЫН МЕТАЛ НУНТАГ” МЕТАЛЛ БОЛОВСРУУЛАХ БИЧИЛ ҮЙЛДВЭРИЙН 2022 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

/АЖ АХУЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ДУГААР:383/

/АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР: 6247814/

ХЯНАСАН: ................................................................/Ж.БАТЗОЛБОО/

НБОГ-ЫН ХБОБНХ-ИЙН МЭРГЭЖИЛТЭН

БОЛОВСРУУЛСАН: ......................................./Г.АНХБАТ/

“ТАЛЫН МЕТАЛ НУНТАГ” ХХК-ИЙН ТӨСЛИЙН ЗОХИЦУУЛАГЧ

УЛААНБААТАР ХОТ ТАЛЫН МЕТАЛ НУНТАГ ХХК 6247814 1117253222

## Гарчиг

**БҮЛЭГ 1.** ТУХАЙН ЖИЛИЙН БИЗНЕС ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА .. 2

**БҮЛЭГ 2.** СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ....3

**БҮЛЭГ 3.** ОРЧНЫ ТОХИЖИЛТ, НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ..................7

**БҮЛЭГ 3.** ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ..............................11

**БҮЛЭГ 4.** ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ ................................12

**БҮЛЭГ 5.** ТУХАЙН ЖИЛИЙН БОМТ-Г ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ........................................................................13

**Хавсралт**

- Хог хаягдал тээвэрлэх, хураамж төвлөрүүлэх гэрээ
- Нийслэлийн Баянгол дүүргийн 20 дугаар хорооны иргэдийн нийтийн хурлын тогтоол
- Нийслэлийн Баянгол дүүргийн 20 дугаар хорооны иргэдийн нийтийн хурлын тэмдэглэл
- Ерөнхий үнэлгээний дүгнэлт
- Үйлдвэрийн байрны гадна талбайд бүх нийтийн цэвэрлэгээ хийсэн байдал
- ухайн жилийн БОМТ-ний хэрэгжилтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөөний биелэлт

## *Зургийн жагсаалт*

Зураг 1.Гадна тохижилтын ажил гүйцэтгэл ..................................................................... 5

Зураг 2.Үйлдвэрийн байр хойд талаас харагдах байдал ................................................ 8

Зураг 3. Үйлдвэрийн байрны баруун хойд талын харагдах байдал.................................. 8

Зураг 4.Үйлдвэрийн байр урд талаас /хайрга дэвссэн байдал/ ........................................ 9

Зураг.5 Талбайн баруун тал /асфальт, хайрга дэвссэн байдал/ ....................................... 9

Зураг 6. Ногоон байгууламж бий болгох талбайн бэлтгэл ажил.......................................10

Зураг 7. Хог хаягдал түр хадгалах цэг..............................................................................11

Зураг 8. "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөн........................................................ ............30

# БҮЛЭГ 1. ТУХАЙН ЖИЛИЙН БИЗНЕС ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

**Тусгай зөвшөөрлийн нэр**: “Төмөрлөг боловсруулах, машины үйлдвэрлэл эрхлэх”

**Төсөл хэрэгжүүлэгч байгууллага**: “Талын метал нунтаг” ХХК

**Регистрийн дугаар, улсын бүртгэлийн дугаар**: 6247814, 9011713027

**Төсөл хэрэгжүүлэгч хаяг**: Монгол Улс, Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 20-р хороо, ДСАА 1 гудамж, 9 тоот

**Төсөл хариуцсан ажилтны нэр, утас**: Г.Анхбат, 89078935

“Талын метал нунтаг” ХХК нь өөрийн хэрэгжүүлж буй металл боловсруулах бичил үйлдвэр байгуулах төсөлдөө Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсэг, Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийх журмын 3 дугаар зүйл, холбогдох аргачлалын дагуу байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ болон нарийвчилсан үнэлгээг мэргэжлийн эрх бүхий байгууллага “ЖЭМР” ХХК-аар хийлгэсэн болно.

“Талын метал нунтаг” ХХК нь “Степпе Линк” ХХК-тай хамтран 2020 оны 3 дугаар сараас эхлэн үйлдвэрийн барилгын гадна тохижилт, зам талбайн ажлыг нийт 199,143,080 төгрөгөөр гүйцэтгүүлж бэлэн болсон.

Монголын анхны нунтаг төмөрлөгийн үйлдвэр нь 2022 оны 04 дүгээр сарын 11 өдөр нээлтээ хийсэн.

Үйлдвэр нь экспортод чиглэсэн, дэвшилтэт технологид суурилсан байгууламж бөгөөд катодын зэс болон хоёдогч эх үүсвэрийн зэсийг боловсруулж, нэмүү үнэ цэн шингэсэн нунтаг төмөрлөг үйлдвэрлэж байна. Компани нь бүтээгдэхүүнээ экспортлохоос гадна нунтаг төмөрлөгт суурилсан орчин үеийн аж үйлдвэрийн бүтээгдэхүүнүүдийг дотоодод үйлдвэрлэхээр зорин ажиллаж байна.

Бүх төрлийн нунтаг металлд физик, химийн иж бүрэн шинжилгээ хийж гүйцэтгэх Монголын анхны лаборатори үйл ажиллагаа явуулж эхэлсэн. Лабораторийн шинжилгээний орчин үеийн дэвшилтэт тоног төхөөрөмжүүдийг ХБНГУ болон АНУ-аас худалдан авч, суурилуулсан.

Лаборатори нь цаашид үйлдвэрийн бүтээгдэхүүн хөгжүүлэлтээс гадна автомашины жижиг эд ангийг бага хэмжээгээр үйлдвэлэх боломжтой.

# БҮЛЭГ 2. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Үйлдвэрийн объектууд төвийн дулааны болон цэвэр бохир усны шугам сүлжээнд холбогдож техникийн нөхцөлөө авсан бөгөөд сар бүр цахилгаан, дулаан, ус ашигласны төлбөрийг төлж байна. Үүнд:

1. Улаанбаатар хотын Ус сувгийн удирдах газар: Цэвэр усаар хангах, хэрэглээнээс гарсан бохир ус татан зайлуулах гэрээ
2. УБДС ТӨХК: Нийслэлийн хотын төвлөрсөн дулаанд холбогдож дулааны эрчим хүчээр хангагдаж байна.
3. Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн баруун түгээх

"Талын метал нунтаг" ХХК-ийн сүүлийн 12 сарын цахилгааны хэрэглээ



## "Талын метал нунтаг" ХХК-ийн Ус, Дулааны төлбөрийн мэдээлэл






## 1. Хүн техникийн хөдөлгөөнөөс тоосжилт үүсэхээс урьдчилан сэргийлэх

Хүн техникийн хөдөлгөөнөөс тоосжилт үүсэхээс сэргийлж үйлдвэрийн гадна тохижилт, зам талбайн ажилд 279,216,424₮ төсөвлөн ажил бүрэн дууссан. Үйлдвэрийн талбайн зураг төслийн дагуу машин механизм зорчих хэсгийг хатуу хучилттай болгож, явган хүний зам талбайд зориулалтын хавтан дэвсэх ажлыг хийсэн. Мөн оффисын байрны гаднах зурвас хэсэг болон хашааны гадна талын авто зогсоолын хэсэгт ногоон байгууламж бий болгож 15 ширхэг Голт бор мод тарьсан.

Зураг 1 Гадна тохижилтын ажил гүйцэтгэл




Гадна талбайн асфальт бетоноор хучигдаагүй бүх талбайг 10/20мм голчтой хайрга дэвсэж орчны тоосжилтоос хамгаалсан.



Гадна орчны тохижилтын хүрээнд орчны тоос шороноос хамгаалж 40x40x10см хэмжээтэй даацын эко хавтанг суурилуулсан.



Дотор тохижилтын ажлын хүрээнд 15 Голт бор мод тарьсан.



0.4 КВ-ын агаарын дэд станцад суурь блокоор хашаа хийж орчны аюулгүй байдлыг хангасан



Авто замын дагуу нийтийн эзэмшлийн явган хүний зам хийж гүйцэтгэсэн бөгөөд зориулалтын явган хашааг татсан болно.

# БҮЛЭГ 3. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

## *Үйлдвэрийн талбайн тохижилтын ажил хийгдсэн байдал*

Үйлдвэрийн бүс нийт 8200 м² талбайтай бөгөөд үүнээс 2550 м² талбайг хатуу хучилттай, 4580 м² талбайд хайрга чулуу дэвсэж тоос шороо босох, хүн техникийн хөдөлгөөнөөр талхлагдахаас сэргийлсэн.

ХУЧИЛТЫН АЖИЛ

| Шифр | Ажлын нэр | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Дундаж зэрэг Тариф | Нэгж хүн-цаг | Нийт хүн-цаг | Бүгд цалин | Нэмэгдэл цалин | Амралтын нэмэгдэл | Нийт цалин |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 25-06-01 | Халуун асфальтбетон хольцоор хучилт байгуулах өнгө асфальт 3 см | 1м3 | 39 | 3.3 / 5444 | 0.51 | 19.84 | 108031 | 16313 | 0 | 124343 |
| 25-00-01 | Халуун асфальтбетон хольцоор хучилт байгуулах Суурь асфальт 4 см | 1м3 | 52 | 3.3 5444 | 0.51 | 26.45 | 144041 | 21750 | 0 | 165791 |
| 25-05-06 | Буталсан чулуун хольцыг автогрейдерээр тэгшлэж суурь байгуулах | 1м3 | 260 | 3.3 5444 | 0.09 | 22.32 | 121487 | 18345 | 0 | 139832 |
| 25-05-02 | Суурийн доод үе байгуулах ХХҮе | 1м3 | 260 | 3.0 5207 | 0.19 | 48.68 | 253496 | 38278 | 0 | 291774 |
| 25-12-02 | Замын хашлага тавих | 1у.м | 140 | 3.1 5286 | 0.32 | 44.34 | 234393 | 35393 | 0 | 269736 |
| 25-12-01 | Явган хүний замын хашлага тавих | 1у.м | 60 | 3.1 5286 | 0.19 | 11.52 | 60907 | 9197 | 0 | 70104 |
| 25-07-20 | Явган хүний замын суурийг элс-хайрганы хольцоор хийх | 1м3 | 43.97 | 3.4 5523 | 0.26 | 11.47 | 63344 | 9565 | 0 | 72909 |
| 25-07-22 | Явган хүний замын хучилтийг өнгөт хавтангаар хийх | 1м2 | 166 | 3.7 5761 | 0.26 | 43.98 | 253383 | 38261 | 0 | 291643 |
| 26-07-19 | Ус зайлуулах лотки суурилуулах | 1у.м | 45 | 3.5 / 5602 | 1.23 | 55.38 | 310240 | 46846 | 0 | 357086 |
| 25-04-66 | Шороон талбайн тэгшилгээ | 1м3 | 734.344 | 4.0 5998 | 0.06 | 45.83 | 274891 | 41509 | 0 | 316399 |
| 25-04-06 | Экскаватораар хөрс ухаж шилж??лэх | 1м3 | 734.344 | 4.0 5998 | 0.06 | 45.83 | 274891 | 41509 | 0 | 316399 |
| 25-20-02 | Тэгшилсэн шороог дорпүрт индүүгээр нягтруулах | 1м3 | 734.344 | 0.0 / 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| 25-07-23 | Гадна зогсоолын эко хавтан суурилуулах | 1м2 | 271.7 | 3.5 / 5602 | 0.16 | 43.75 | 245067 | 37005 | 0 | 282073 |



Зураг 2.Үйлдвэрийн байр хойд талаас харагдах байдал




Зураг 3. Үйлдвэрийн байрны баруун хойд талын харагдах байдал



Зураг 4.Үйлдвэрийн байр урд талаас /хайрга дэвссэн байдал/




Зураг.5 Талбайн баруун тал /асфальт, хайрга дэвссэн байдал/



Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн ажлын хүрээнд нийтдээ 199,143,080 төгрөг зарцуулсан ба дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

### *Ногоон байгууламж бий болгосон байдал*

Газрын тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.6-д заасны дагуу "эзэмшилд авсан газрын 10-аас доошгүй хувьд ногоон байгууламж байлгана" гэж заасны дагуу үйлдвэрийн талбайн тодорхой хэсгүүдэд тохижилтын ажил хийж, зурвас газруудад ногоон байгууламж бий болгосон.

Зураг 6. Ногоон байгууламж бий болгох талбайн бэлтгэл ажил



Ногоон байгууламж бий болгох талбайн хөрсийг бэлдсэн айдал



Гадна талбайд дэвсэх ногоон зүлгийг бэлтгэж бэлэн болсон.

# БҮЛЭГ 3. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Тайлант онд хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд 3,500,00 төгрөг зарцуулсан.

### *Хог хаягдлын түр цэг*

Хог хаягдлыг ангилан ялгаж хаях зориулалтын тасалгаатай хогийн сав байрлуулсан. Үйлдвэрийн үйл ажиллагаа бүрэн жигдрээгүй байгаа учир өдөр тутамд гарч буй хог хаягдлын хэмжээ бага байна. Гэсэн хэдий ч ажилчдын ахуйн хэрэглээ болон барилгын ажлын үед гарч буй хог хаягдал тус бүрийг ангилан ялгах ажил хийгдэж байна.

Зураг 7. Хог хаягдал түр хадгалах цэг




### *Хог хаягдал ачуулах, тээвэрлэх үйл явц*

2022.07.01 Баянгол Шинэ Өргөө ОНӨААТҮГ-тай Хог хаягдал тээвэрлэх, хураамж төвлөрүүлэх гэрээ, Баянгол дүүргийн 20-р хорооны Засаг даргатай Тохижилт цэвэрлэгээний гэрээг тус тус байгуулж тухай бүр хог хаягдлаа ачуулж байна. Мөн хог хаягдлын гэрээний дагуу улирал бүр 150,000 төгрөгийг хог ачуулах тээвэрлэх зардалд зарцуулж байна.

# БҮЛЭГ 4. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ

STEPPE METAL POWDER

**"Талын метал нунтаг" ХХК**



ЖЭМР

*"Металл боловсруулах бичил үйлдвэр" төслийн*

**Байгаль Орчны Нөлөөллийн Нарийвчилсан Үнэлгээний нэмэлт тодотгол тайлан**

Улаанбаатар хот
2022 он


Утас: 976 89078935
Имэйл: ankhbat@smp.mn

Батлав.
БОАЖЯ-ны Ерөнхий шинжээч: Г.Энхмөнх

Хянасан:
БОАЖЯ-ны Шинжээч:

# УЛААНБААТАР ХОТЫН БАЯНГОЛ ДҮҮРГИЙН 20-Р ХОРООНЫ НУТАГ ДЭВСГЭРТ ХЭРЭГЖИЖ БУЙ "МЕТАЛЛ БОЛОВСРУУЛАХ БИЧИЛ ҮЙЛДВЭР" ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ НӨЛӨӨЛЛИЙН НАРИЙВЧИЛСАН ҮНЭЛГЭЭНИЙ НЭМЭЛТ ТОДОТГОЛ ТАЙЛАН

"Талын метал нунтаг" ХХК-ийн Гүйцэтгэх захирал
Б.Асхар

БОННҮнэлгээ хийж тайлан боловсруулсан: Газар, Байгаль орчны зөвлөх "ЖЭМР" ХХК-ийн Ерөнхий захирал
Р.Оюун

Улаанбаатар хот
2022 он

# Агуулга


Бүлэг 1. Тайлангийн техникийн бус хураангуй

Бүлэг 2. Оршил

Бүлэг 3. Үйл ажиллагааны хүрээ

Бүлэг 4. Төслийн тодорхойлолт

Бүлэг 5. Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл, үнэлгээ

Бүлэг 6. Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ

Бүлэг 7. Эрсдэлийн үнэлгээ, менежмент

Бүлэг 8. Гол үр дүнгүүд ба нэгдсэн дүгнэлт

Ашигласан мэдээ, материал

Хавсралт

## Гарчиг

**ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР** ..... 10
**БҮЛЭГ 1. ТАЙЛАНГИЙН ТЕХНИКИЙН БУС ХУРААНГУЙ** ..... 11
1.1. Төсөл хэрэгжих нутгийн байгаль орчны өнөөгийн төлөв ..... 11
1.2. Төслөөс байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл, хохирол, бууруулах, арилгах арга хэмжээ, зөвлөмж ..... 12
*1.2.1. Байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл, бууруулах, арилгах арга хэмжээ, зөвлөмж* ..... *12*
*1.2.2. Нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөөлөл, бууруулах арга хэмжээ, зөвлөмж* ..... *14*
1.3. Эрсдэлийн үнэлгээ, менежмент ..... 15
*1.3.1. Байгалийн гэнэтийн аюул, осол, эрсдэлийн үнэлгээ* ..... *15*
*1.3.2. Химийн бодисын эрсдэлийн үнэлгээ* ..... *15*
*1.3.3. Эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа* ..... *16*
1.4. Байгаль орчны менежментийн төлөвлөгөө ..... 16
1.5. Төслийн баримт бичгийн бүрдүүлэлт ..... 18
**БҮЛЭГ 2. ОРШИЛ** ..... 19
2.1. Төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний гол зорилго ..... 22
2.2. Нарийвчилсан үнэлгээний хүрээнд хийсэн ажлууд ..... 22
2.3. Судалгааны ажлуудын гол үр дүн ..... 23
**БҮЛЭГ 3. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭ** ..... 25
3.1. Танилцуулга ..... 25
3.2. Төсөлтэй холбоотой хууль, тогтоомж ..... 25
*3.2.1. Засгийн газрын тогтоол, бусад дүрэм, журам* ..... *34*
3.3. Байгаль орчин, ХАБЭА-н стандартууд ..... 38
3.4. Төслийн үйл ажиллагаанд холбогдолтой эрх зүйн шийдэл ..... 42
**БҮЛЭГ 4. ТӨСЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ** ..... 43
4.1. Төслийн зорилго ..... 43
4.2. Цар хүрээ, хэмжээ ..... 43
4.3. Төсөл хэрэгжүүлэх үе шат ..... 44
4.4. Үйлдвэрлэлийн төлөвлөгөө ..... 46
4.5. Төсөл хэрэгжүүлэх хэрэгцээ, шаардлага ..... 47
4.6. Түүхий эд, байгалийн баялгийн ашиглалт ..... 50
*4.6.1. Үндсэн түүхий эд* ..... *50*
4.7. Усны хэрэглээ ..... 51
4.8. Эрчим хүч ..... 51
4.9. Дулааны хэрэглээ ..... 51
4.10. Техник, технологийн сонголт хүчин чадал ..... 52
4.11. Үйлдвэрийн процесс ..... 54
*4.11.1. Түүхий эд хайлах* ..... *55*
*4.11.2. Нунтаглах атомжуулах* ..... *56*

*4.11.3. Усгүйжүүлэх ........ 56*
*4.11.4. Хатаах ........ 57*
*4.11.5. Шигшилт, холилт, уутлалт ........ 58*
*4.11.6. Савлах ........ 58*
4.12. ТҮҮХИЙ ЭД, БҮТЭЭГДЭХҮҮНИЙ АГУУЛАХ ........ 59
4.13. ТӨСЛИЙН ЭЦСИЙН БОЛОН ЗАВСРЫН БҮТЭЭГДЭХҮҮН ........ 61
4.14. ГАРАХ ХАЯГДАЛ, ЯЛГАРАЛ ТҮҮНИЙГ ЭРГҮҮЛЭН АШИГЛАХ, ЗАЙЛУУЛАХ АРГА ЗАМ ........ 63
4.15. ТӨСЛИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД ........ 63
*4.15.1. Борлуулалт түгээлт, тээвэрлэлт, хөрөнгө оруулалт ........ 63*
*4.15.2. Хөрөнгө оруулалт ........ 65*
*4.15.3. Гол өрсөлдөгчид /Үйлдвэрлэгчид/ ........ 65*
*4.15.4. Зорилтот зах зээл ........ 66*
*4.15.5. Бүтээгдэхүүний хольц ........ 67*
*4.15.6. Үнийн бүтэц ........ 68*
*4.15.7. Борлуулалтын бүтэц ........ 69*
*4.15.8. Ажиллах хүч, хөдөлмөр хамгаалал, аюулгүй байдал ........ 69*
*4.15.9. Улс болон орон нутгийн төсөвт оруулах хувь нэмэр ........ 71*
**БҮЛЭГ 5. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ, ҮНЭЛГЭЭ ........ 72**
5.1. ЦАГ АГААР, УУР АМЬСГАЛЫН ХҮЧИН ЗҮЙЛ ........ 76
*5.1.1. Нарны гийгүүлэлт болон цацрагийн хэмжээ ........ 76*
*5.1.2. Агаарын температур ........ 77*
*5.1.3. Хур тунадасны горим ........ 80*
*5.1.4. Агаарын даралт, салхины горим ........ 81*
5.2. АГААРЫН ЧАНАРТ ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛЛИЙН ҮНЭЛГЭЭ ........ 83
5.3. ФИЗИК БОХИРДОЛ, ХОГ ХАЯГДАЛ ........ 86
5.4. ГАДАРГЫН БОЛОН ГАЗРЫН ДООРХ УСАНД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛЛИЙН ҮНЭЛГЭЭ ........ 93
5.5. ГАЗАР, ХӨРСӨН БҮРХЭВЧИД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛЛИЙН ҮНЭЛГЭЭ ........ 104
5.6. УРГАМЛАН НӨМРӨГТ ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛЛИЙН ҮНЭЛГЭЭ ........ 107
5.7. АМЬТНЫ АЙМАГТ ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛЛИЙН ҮНЭЛГЭЭ ........ 107
5.8. ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР, ТҮҮХ СОЁЛЫН ӨВД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛЛИЙН ҮНЭЛГЭЭ ........ 107
5.9. НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛЛИЙН ҮНЭЛГЭЭ ........ 109
*5.9.1. Нутгийн оршин суугчдад үзүүлэх нөлөөлөл ........ 110*
**БҮЛЭГ 6. СӨРӨГ НӨЛӨӨЛЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ ........ 113**
6.1. АГААРЫН ЧАНАР ........ 113
6.2. ФИЗИК БОХИРДОЛ, ХОГ ХАЯГДАЛ ........ 113
6.3. ГАДАРГЫН БОЛОН ГАЗРЫН ДООРХ УС ........ 114
6.4. ГАЗРЫН ГАДАРГА, ХӨРСӨН БҮРХЭВЧ ........ 114
6.5. НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСАГ ........ 114
6.6. БУСАД ЗӨВЛӨМЖ ........ 114
**БҮЛЭГ 7. ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ, МЕНЕЖМЕНТ ........ 116**
7.1. БАЙГАЛИЙН АЮУЛ, ОСОЛ, ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ ........ 116
*7.1.1. Аргачлал ........ 116*

*7.1.2. Эрсдэлийн үнэлгээний дүн ....... 118*
*7.1.3. Эрсдэл, уршгийн үнэлгээ ....... 120*
*7.1.4. Эрсдлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ ....... 121*
7.2. ХИМИЙН БОДИСЫН ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ ....... 122
*7.2.1. Төсөлд ашиглагдах химийн бодисуудын ерөнхий мэдээлэл ....... 122*
*7.2.2. Хүний эрүүл мэндийн эрсдэлийн үнэлгээ ....... 139*
7.3. ЭРҮҮЛ МЭНД, АЮУЛГҮЙ АЖИЛЛАГАА ....... 167
*7.3.1. Төслийн үйл ажиллагаанаас ажилчдын эрүүл мэндэд нөлөөлөх нөлөөлөл ....... 168*
*7.3.2. Төслийн үйл ажиллагаанаас ажилчдын ЭМАБ-д үзүүлэх бусад нөлөө ....... 170*
*7.3.3. Эрсдэлийг бууруулах арга хэмжээ ....... 170*
*7.3.4. ХАБЭА-н талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ, зөвлөмж ....... 174*
**БҮЛЭГ 8. ГОЛ ҮР ДҮНГҮҮД БА НЭГДСЭН ДҮГНЭЛТ ....... 177**
8.1. НӨЛӨӨЛЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТУХАЙ ....... 177
8.2. БАЙГАЛЬ ОРЧНЫ НӨЛӨӨЛЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ДҮГНЭЛТ ....... 177
8.3. НЭГТГЭСЭН ДҮГНЭЛТ, САНАЛ ....... 178
**АШИГЛАСАН МАТЕРИАЛ ....... 179**

## Зургийн жагсаалт

Зураг 3.1 Төслийн үйл ажиллагаанд холбогдолтой эрх зүйн бүрдүүлэлтийн процесс 42

Зураг 4.1 Төслийн талбайн байршил ... 44

Зураг 4.2 ТНМ ХХК-ийн үйлдвэрлэлийн төлөвлөгөө ... 47

Зураг 4.3 Төслийн ач холбогдол ... 49

Зураг 4.4 Зэс нунтгийн зах зээл ... 50

Зураг 4.5 Катодын зэс 1000мм 1100ммх4мм ... 50

Зураг 4.6 Хаягдал шахмал зэс ... 51

Зураг 4.7 Зэс нунтаг үйлдвэрлэлийн бүдүүвч зураг ... 55

Зураг 4.8 Металл хайлуулах индукцийн зуух ... 55

Зураг 4.9 Атомжуулагч бортого ... 56

Зураг 4.10 Усгүйжүүлэх систем ... 57

Зураг 4.11 Хатаах систем ... 57

Зураг 4.12 Шигших машин ... 58

Зураг 4.13 Савласан эцсийн бүтээгдэхүүн, /металл нунтаг/ ... 59

Зураг 4.14 Катодын зэс хавтан хураах агуулахын план ... 59

Зураг 4.15 Катодын зэс ... 60

Зураг 4.16 Уутгай эцсийн бүтээгдэхүүн ... 60

Зураг 4.17 Эцсийн бүтээгдэхүүн хураах талбай ... 61

Зураг 4.18 Төмөр савтай эцсийн бүтээгдэхүүн, бүтээгдэхүүний жин ... 61

Зураг 4.19 Зэсийн нунтгийн зах зээл, эцсийн хэрэглэгчид ... 62

Зураг 4.20 Зэсийн нунтгийн зах зээл, бүтээгдэхүүний жишээ ... 63

Зураг 4.21 Гурав дах жилээс хойших зорилтот борлуулалт, тн, хувиар ... 67

Зураг 4.22 Гурав дах жилээс хойших борлуулалт /зах зээлээр/ ... 68

Зураг 4.23 Хүний нөөцийн бүтэц ... 70

Зураг 5.1 Цаг уурын станцуудын байршил ... 76

Зураг 5.2 Нарны нийлбэр цацрагийн хэмжээ ... 76

Зураг 5.3 Жилийн дундаж агаарын температурын хэлбэлзэл ... 77

Зураг 5.4 Агаарын температурын сарын хэлбэлзэл, олон жилийн дунджаар ... 77

Зураг 5.5 Агаарын дундаж температурын улирлын хэлбэлзэл, олон жилийн дунджаар, Буянт-Ухаа станц ..... 78
Зураг 5.6 Агаарын харьцангуй чийгшлийн хэмжээ, жилийн дунджаар ..... 79
Зураг 5.7 Агаарын харьцангуй чийгшлийн хэмжээ, сарын өөрчлөлт ..... 79
Зураг 5.8 Агаарын харьцангуй чийгшлийн улирал, жилийн хэлбэлзэл ..... 80
Зураг 5.9 Хур тунадасны хэмжээ, жилийн дунджаар ..... 80
Зураг 5.10 Хур тунадасны хэмжээ, улирлын хэлбэлзэл ..... 81
Зураг 5.11 Агаарын даралтын утга, жилийн дунджаар ..... 81
Зураг 5.12 Салхины хурд, олон жилийн дунджаар ..... 82
Зураг 5.13 Буянт-Ухаа станцын салхины зүгийн давтагдал, хурд ..... 82
Зураг 5.14 Агаар мандал дах тоосонцоруудын харьцангуй агууламж Чов(1995). Ватсан (2002) нарын тодорхойлсноор ..... 84
Зураг 5.15 Хүхэрлэг хийн шинжилгээний дүн ..... 85
Зураг 5.16 Агаарын чанарын дээж авсан цэгийн байршил ..... 86
Зураг 5.17 Дуу шуугианы хэмжилтийн хамгийн их болон хамгийн бага утга ..... 87
Зураг 5.18 Дуу чимээний хэмжилт хийсэн цэгийн байршил ..... 88
Зураг 5.19 Цацрагийн хэмжилт хийсэн цэгийн байршил ..... 89
Зураг 5.20 Хөрсөн дэх байгалийн цацраг идэвхит $^{226}Ra$ изотопийн хувийн идэвхийн түгэлт ..... 90
Зураг 5.21 Хөрсөн дэх байгалийн цацраг идэвхит $^{232}Th$ изотопийн хувийн идэвхийн түгэлт ..... 90
Зураг 5.22 Хөрсөн дэх байгалийн цацраг идэвхит $^{40}K$ изотопийн хувийн идэвхийн түгэлт ..... 91
Зураг 5.23 Үйлдвэрийн технологийн усны эргэлтийн систем ..... 95
Зураг 5.24 Туул голын жилийн урсцын гидрограф (Туул-Улаанбаатар) ..... 97
Зураг 5.25 Ус хурах талбай, ус урсах сүлжээний зураг ..... 100
Зураг 5.26 Улаанбаатар хот орчмын голын тооцоолсон өнгөрөлт ..... 100
Зураг 5.27 Судалгааны талбайн гол, сайр болон үерийн өртөнг, эмзэг байдал, эрсдэл, аюул (100 жилээр тооцсоноор) ..... 101
Зураг 5.28 Талбайн хоосон орон зайг дүүргэн тэгшилж хатуу хучилттай болгосон байдал ..... 105
Зураг 5.29 Орчны тохижилт хийсэн байдал ..... 106

Зураг 5.30 Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээний зураг ............. 108
Зураг 5.31 Төслийн талбайн эргэн тойрны газар ашиглалт ............. 111
Зураг 5.32 Одоогийн газар ашиглалтын бүсчлэл ............. 111
Зураг 5.33 2030 оны төлөвлөлт ............. 112
Зураг 7.1 Улаанбаатар хотын газар хөдлөлтийн бичил мужлал ............. 118
Зураг 7.2 Улаанбаатар хотын орчмын газар хөдлөлтийн хагарал ............. 119
Зураг 7.3 Улаанбаатар хотын орчмын газар хөдлөлтийн хагарал ............. 119
Зураг 7.4 Химийн бодис, бүтээгдэхүүнийг тэсвэрлэх шалтай агуулах ............. 160
Зураг 7.5 Хамгаалалттай гэрэлтүүлэг ба гэрлийн хамгаалалт ............. 161
Зураг 7.6 Химийн бодист тэсвэртэй нэг бүрийн хамгаалах хувцас, хэрэгсэл ...... 162
Зураг 7.7 Химийн бодис асгарсан, алдагдсан үед ашиглах багаж хэрэгсэл, шингээгч материал ............. 162
Зураг 7.8 Нүд угаах болон биеийн бодист өртсөн хэсгийг угаах зориулалтын шүршүүр ............. 162

## Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1.1 Байгаль орчинд үзүүлэх гол сөрөг нөлөөлөл, бууруулах, арилгах арга хэмжээ, зөвлөмж ... 13
Хүснэгт 1.2 БОМТ-г хэрэгжүүлэх төсвийн тооцоо (2022-2026 он) ... 16
Хүснэгт 1.3 Баримт бичгийн бүрдүүлэлт ... 18
Хүснэгт 2.1 Ерөнхий үнэлгээний гүйцэтгэлийн хуудас ... 19
Хүснэгт 4.1 GGP-ийн ирүүлсэн инженерийн зураг төсөл, мэдээллүүд ... 45
Хүснэгт 4.2 Технологи шилжүүлэх, тоног төхөөрөмж угсрах ажлын хуваарь ... 46
Хүснэгт 4.3 Тоног төхөөрөмжийн жагсаалт ... 52
Хүснэгт 4.4 Зэс суурьтай металл нунтаг үйлдвэрлэгчид (2017 оны байдлаар) ... 65
Хүснэгт 4.5 Дундаж конверс үнэ ($) ... 68
Хүснэгт 4.6 GGP METALPOWDER AG-ийн олон улс дах оффис ба агентууд ... 69
Хүснэгт 5.1 Байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл ... 73
Хүснэгт 5.2 Олон жилийн агаарын дундаж температур ($^0$C), сараар ... 77
Хүснэгт 5.3 Олон жилийн агаарын дундаж температур ($^0$C), улирлаар ... 78
Хүснэгт 5.4 Агаарын чанарын шинжилгээний дүн ... 84
Хүснэгт 5.5 Дуу шуугианы хэмжилтийн үр дүн /10 минутын дунджаар/ ... 87
Хүснэгт 5.6 Хөрсний цацрагийн дээж авсан цэгийн байршил ... 89
Хүснэгт 5.7 Хөрсний дээжүүдийн агаарт шингэсэн цацрагийн тунгийн чадал ... 90
Хүснэгт 5.8 Хог хаягдлын эх үүсвэр, хэмжээ, тээвэрлэх арга хэлбэр ... 92
Хүснэгт 5.9 Хүн амын унд, ахуйн хэрэглээний түр норм ... 93
Хүснэгт 5.10 Ажилчдын унд ахуйн хэрэглээний усны тооцоо ... 93
Хүснэгт 5.11 Зүлэг талбайн усалгааны түр норм ... 94
Хүснэгт 5.12 Жилд хэрэглэгдэх усалгааны усны хэрэглээ ... 94
Хүснэгт 5.13 Зарцуулах усны тооцоо ... 94
Хүснэгт 5.14 Үйлдвэрийн хэрэглээний нөхөн сэлбэгдэх усны тооцоо ... 94
Хүснэгт 5.15 Ус судлалын харуул ... 96
Хүснэгт 5.16 Янз бүрийн бүрийн хангамшил бүхий жилийн дундаж урсац ... 97
Хүснэгт 5.17 Олон жилийн дундаж урсац ... 97
Хүснэгт 5.18 Хур борооны үерийн их урсац ... 98

Хүснэгт 5.19 Гол мөрний хамгийн бага урсац ..... 98
Хүснэгт 5.20 Сэлбэ голын ус судлалын харуулын мэдээ /ОЖД/ ..... 99
Хүснэгт 5.21 Ус хурах талбай, ус урсах голдирлын тоо ..... 99
Хүснэгт 5.22 Туул голын сав газар дах ус агуулагч бүрдэл, бүсийн гидрогеологийн зарим үзүүлэлт ..... 102
Хүснэгт 5.23 Төвийн шугамын усны шинжилгээний дүн ..... 104
Хүснэгт 5.24 Тусгай хамгаалалттай газар нутаг ..... 108
Хүснэгт 5.25 Нийгэм, эдийн засагт учирч болзошгүй нөлөөллийн үнэлгээ ..... 109
Хүснэгт 7.1 Үр дагавар буюу нөлөөллийн чанарын үнэлгээний шалгуур ..... 117
Хүснэгт 7.2 Магадлалын үнэлгээний шалгуур ..... 117
Хүснэгт 7.3 Эрсдэлийн чанарын үнэлгээний матриц ..... 117
Хүснэгт 7.4 Эрсдэлийн зэрэглэлийн тайлбар ..... 118
Хүснэгт 7.5 Байгалийн гэнэтийн аюул, эрсдэлийн үнэлгээ ..... 120
Хүснэгт 7.6 Эрсдэлийг бууруулах талаар авах арга хэмжээ, зөвлөмж ..... 121
Хүснэгт 7.7 Химийн бодисуудын нэр төрөл, хэмжээ, зориулалт ..... 122
Хүснэгт 7.8 Химийн бодисуудын шинж чанарын тодорхойлолт ..... 124
Хүснэгт 7.9 Ашиглагдах химийн бодисуудын хор аюулын ангилал, хоруу чанар ... 129
Хүснэгт 7.10 Ашиглагдах химийн бодисуудын онцлог шинж чанар ..... 134
Хүснэгт 7.11 Хүний эрүүл мэндийн эрсдэлийн үнэлгээний түлхүүр асуулт ..... 139
Хүснэгт 7.12 Өртөгчтэй холбоотой тулгуур мэдээлэл ..... 140
Хүснэгт 7.13 Хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөлөл, хоруу чанар ..... 141
Хүснэгт 7.14 Химийн бүтээгдэхүүний хүний эрүүл мэндэд үзүүлэх эрсдлийн дүр зураг ..... 146
Хүснэгт 7.15 Эрсдэл үүсэх магадлалын үнэлэмж ..... 147
Хүснэгт 7.16 Төсөл хэрэгжих явцад үүсэж болзошгүй эрсдэлийн тодорхойлолт ..... 147
Хүснэгт 7.17 Байгаль орчны эрсдлийн үнэлгээний түлхүүр асуулт ..... 150
Хүснэгт 7.18 Байгаль орчин, экологид үзүүлэх нөлөөлөл, хоруу чанар ..... 150
Хүснэгт 7.19 Агуулахад хадгалах химийн бодисуудын аюулын тэмдэглэгээ, дохио үг ..... 153
Хүснэгт 7.20 Ашиглагдаж байгаа химийн бодисын хадгалах нөхцөл, гал унтраах материал ..... 157

Хүснэгт 7.21 Химийн бодис, бүтээгдэхүүнээс үүсэх хог хаягдлын ангилал .............. 163

# Товчилсон үгийн тайлбар

| | |
|---|---|
| АНУ | Америкийн Нэгдсэн Улс |
| ААНОАТ | Аж ахуй нэгжийн орлогын албан татвар |
| БОАЖЯ | Байгаль орчин аялал жуулчлалын яам |
| БОЭҮ | Байгаль орчны эрсдэлийн үнэлгээ |
| БОМТ | Байгаль орчны менежментийн төлөвлөгөө |
| БОННҮ | Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ |
| БОХШХ | Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөр |
| БГД | Баянгол дүүрэг |
| ГНС | Газрын нэгдмэл сан |
| ЗДХ | Зөвшөөрөгдөх дээд хэмжээ |
| ЗГ | Засгийн Газар |
| ИНХ | Иргэдийн нийтийн хурал |
| МУШУАГЭХ | Монгол улсын шинжлэх ухааны академийн Геоэкологийн хүрээлэн |
| МҮОНРТ | Монголын үндэсний олон нийтийн радио телевиз |
| МҮЭСТО | Монголын үйлдвэрчний эвлэлийн соёлын төв ордон |
| ОХШХ | Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр |
| ОНӨААТҮГ | Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар |
| ОАЭҮ | Осол аюул эрсдлийн үнэлгээ |
| НИТХ | Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурал |
| ТХГН | Тусгай хамгаалалттай газар нутаг |
| ТМН | Талын метал нунтаг |
| ТЦБ | Төв цэвэрлэх байгууламж |
| ҮАЖ | Үйл ажиллагааны журам |
| УИХ | Улсын их хурал |
| УЦУОШГ | Ус цаг уур орчны шинжилгээний газар |
| УСУГ | Ус сувгийн удирдах газар |
| ХАБЭА | Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй |
| ХАБ | Хөдөлмөрийн аюулгүй байдал |
| ХЭА | Хөдөлмөрийн эрүүл ахуй |
| ХХАОАТ | Хувь хүний орлогын албан татвар |
| ХАОАТ | Хүн амын орлогын албан татвар |
| ХЭМЭҮ | Хүний эрүүл мэндийн эрсдэлийн үнэлгээ |
| ХХК | Хязгаарлагдмал хариуцлагатай компани |
| ШУА | Шинжлэх ухааны академи |
| кг | килограмм |
| $м^2$ | метр квадрат |
| м | метр |
| м/с | метр секунд |
| мян.төг | мянган төгрөг |
| тн | тонн |
| сая.төг | сая төгрөг |

# БҮЛЭГ 5. ТУХАЙН ЖИЛИЙН БОМТ-Г ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2019 онд төслийн үйл ажиллагаа эхлэхийн өмнө байгаль орчны одоогийн суурь нөхцөлийн судалгаа, байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ, байгаль орчны менежментийн төлөвлөгөөг /цаашид "БОМТ" гэх/ "ЖЭМР" ХХК-аар гүйцэтгүүлж БОАЖЯ-аар баталгаажуулсан. БОМТ-г 5 жилээр боловсруулсан хэдий ч хууль эрх зүйн хүрээнд жил бүр тодотгон боловсруулж төрийн захиргааны төв байгууллагаар батлуулж, хэрэгжүүлэх үүрэгтэй байдаг. Энэхүү ажлын хүрээнд төслийн үйл ажиллагаатай уялдуулан байгаль орчныг хамгаалах чиглэлээр хийж гүйцэтгэсэн ажлаараа 2022 оны тухайн жилийн БОМТ-ний биелэлтийн тайланг боловсруулсан болно. Дурдсан ажлыг тухай бүр мэргэжлийн эрх бүхий байгууллагаар гүйцэтгүүлсэн.

Ажилчдын хөдөлмөр аюулгүй байдлыг хангаж зориулалтын хувцас хэрэгслээр хангасан.

Мөн БОМТ-ний чухал бүрэлдэхүүн хэсэг болох орчны хяналт шинжилгээг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлж, үр дүнг биелэлтийн тайланд тусгав.

Агаар, ус, хөрс, дуу чимээний хэмжилт судалгааны дүнгээс үзэхэд МУ-ын стандарт нормд заасан хэмжээнд буюу төслийн үйл ажиллагаанаас хүрээлэн буй орчинд сөрөг нөлөөлөл байхгүй байна.  Нэг талаас Баянгол дүүргийн Цагдаагийн хоёрдугаар хэлтэстэй хамтран тухайн нутаг дэвсгэрт иргэд оршин суугчид нь амьдрахад таатай, аюулгүй амар тайван орчин бүрдүүлэхэд чиглэсэн гадна талын хяналтын 15 камер суурилуулсан болно.

"Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд "Талын метал нунтаг" ХХК-ийн ажилчид "Баянгол цэцээрлэгт хүрээлэн" ОНӨТҮГ -ын талбайд байгуулсан төгөлд 1,280,000₮ зардлаар 16 ширхэг нарс мод тарьж ирээдүй хойч үедээ үлдээх эрүүл ногоон орчныг бүтээхэд бодит хувь нэмэр орууллаа.

2022 оны 8 дугаар сарын 12 өдөр Баянгол Дүүргийн Засаг даргын А/352 дугаар захирамжийн дагуу бүх нийтийн цэвэрлэгээнд оролцож хог хаягдал болон шарилж лууль зэргийг цэвэрлэж, зурагт тайланг илгээсэн болно.




Зураг 8. "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөн



## 1.8 ЕРӨНХИЙ ҮНЭЛГЭЭНИЙ ДҮГНЭЛТ

МОНГОЛ УЛСЫН
БАЙГАЛЬ ОРЧИН,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ

2022.01.24 № 13/420

Танай ______ -ны №

"ТАЛЫН МЕТАЛЛ НУНТАГ" ХХК-Д

Ерөнхий үнэлгээний дүгнэлт
хүргүүлэх тухай

Танай компаниас ирүүлсэн Улаанбаатар хотын Баянгол дүүргийн 20 дугаар хорооны нутагт хэрэгжүүлж буй "Металл боловсруулах бичил үйлдвэрийн төсөл"-д "Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай" хуулийн 7 дугаар зүйлийн 7.3, "Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийх журам"-ын 3 дахь хэсгийг үндэслэн, байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ хийлээ.

Ерөнхий үнэлгээний дүнгээр уг төсөлд аргачлалын дагуу байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ /нэмэлт тодотгол/ хийлгэх шаардлагатай гэж үзэв.

Төсөл хэрэгжүүлэгч нь Ерөнхий үнэлгээний гүйцэтгэлийн хуудаст заасан нарийвчилсан үнэлгээний явцад тодруулах асуудлууд, онцгойлон анхаарах чиглэлийг харгалзан байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан, байгаль орчны менежментийн төлөвлөгөөг эрх бүхий мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлж, 2022 оны 4 дүгээр улиралд багтаан тус яаманд ирүүлэхийг үүгээр мэдэгдье.

Ерөнхий үнэлгээний гүйцэтгэлийн хуудсыг хавсаргав.

Хавсралт ...... хуудастай.

ЕРӨНХИЙ ШИНЖЭЭЧ Г.ЭНХМӨНХ

**БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ**

**ЕРӨНХИЙ ҮНЭЛГЭЭНИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙН**
**ХУУДАС**

**2022 оны 01-р сарын 19** **Улаанбаатар хот**

**Төслийн дугаар** **Дугаар 2022/J 005**

***Төсөл хэрэгжүүлэгчийн нэр, хаяг:*** "Талын металл нунтаг" ХХК, регистрын дугаар-6247814, Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 20-р хороо, ДСАА, 1-р гудамж, 9 тоот.

***Төслийн нэр:*** Металл боловсруулах бичил үйлдвэрийн төсөл.

***Төсөл хэрэгжих нутаг дэвсгэр, байршил:*** Улаанбаатар хотын Баянгол дүүргийн 20 дугаар хорооны нутагт, нийслэлийн Засаг даргын 2020 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн А/552 дугаар захирамжаар /төсөл хэрэгжүүлэгч П.Цагааны нэр дээр/ үйлдвэрлэлийн зориулалтаар олгосон нийт 4955 м$^2$ газарт хэрэгжинэ.

**Байгаль орчны төлөв байдлын үнэлгээ:** Төсөл хэрэгжих газрын Байгаль орчны төлөв байдлын үнэлгээг "ЖЭМР" ХХК гүйцэтгэсэн байна.

***Холбоо барих утас:*** 976-7507-99(0.

***Орон нутгийн санал:*** Төсөл хэрэгжих Улаанбаатар хотын Баянгол дүүргийн Засаг даргын 2021 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 05/2345 дугаартай албан бичгээр ирүүлсэн санал болон болон төсөл хэрэгжүүлэгчийн 2021 оны 12-р сарын 02-ны өдрийн /E-Mongolia/ 099-2112-000034 дугаартай цахимаар ирүүлсэн Ерөнхий үнэлгээ хийлгэх тухай хүсэлт /нэмэлт тайлбар/ зэргийг харгалзан үзэв.

| | Ерөнхий үнэлгээний гол шалгуурууд | Нийцсэн | Нийцээгүй | Нарийвчилсан үнэлгээ хийх шаардлагатай | Тайлбар, тодруулга |
|---|---|---|---|---|---|
| Байгаль орчныг хамгаалах хууль тогтоомжийн нийцэл | Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа байгаль орчныг хамгаалах болон байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль тогтоомжийн холбогдох заалт | Тийм | | | Нарийвчилсан үнэлгээний явцад хууль тогтоомжийн нийцлийг нарийвчлан тодорхойлох |
| Төрийн бодлого, шийдвэрийн нийцэл | Төрөөс баримтлах бодлогын баримт бичиг, Стратегийн үнэлгээний дүгнэлт, зөвлөмжийн холбогдох заалт | Тийм | | | |
| Төслийн байршил, түүнтэй холбогдох шалгуурууд | Хуулиар хамгаалагдсан газар нутаг байгаа эсэх (урсац бүрэлдэх эх, ойн болон усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, хилийн хамгаалалтын бүс, орон нутгийн тусгай хамгаалалттай газар г.м) | | | Тийм | |
| | Төсөл хэрэгжих нутаг дэвсгэр нь хүний нөлөө, байгаль цаг уурын өөрчлөлтөд эмзэг мэдрэмтгий эсэх | | | Тийм | |
| | Төсөл хэрэгжих нутаг дэвсгэр, түүний ойр орчимд улс, орон нутгийн хэтийн хөгжил, ашиглахаар төлөвлөсөн, сөрөг нөлөөлөлд өртөж болзошгүй газар байгаа эсэх | | | Тийм | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | Болзошгүй хуримтлагдаж нөлөөлөл үүсгэх эсэх | | | Тийм | |
| Төслийн байгаль орчны нөлөөллийн урьдчилсан үнэлгээ | **Агаарын чанар** | | | | |
| | Бохирдуулагч болон аюултай хортой бодис агаар мандалд ялгаруулах, эсэх | | | Тийм | |
| | Дуу чимээ, доргио чичиргээ гэрлийн болон дулааны нөлөөлөл цахилгаан соронзон цацраг үүсэх эсэх | | | Тийм | |
| | **Усан орчин** | | | | |
| | Гадаргын болон газрын доорх усны нөөцийн хомсдол үүсэх, эсэх | | | Тийм | |
| | Цэнгэг усны нөөцийг ашиглах, эсэх | | | Тийм | |
| | Гадаргын болон газрын доорх усанд бохирдол үүсэх эсэх | | | Тийм | |
| | **Хөрсөн бүрхэвч** | | | | |
| | Хөрсөн бүрхэвч эвдрэх, эсэх | | | Тийм | |
| | Хөрс бохирдуулах эсэх | | | Тийм | |
| | Хөрс доройтох, цөлжих эсэх | | | Тийм | |
| | **Ургамлан нөмрөг** | | | | |
| | Ургамалан нөмрөг өртөх эсэх | | | Тийм | |
| | Ховор, нэн ховор ургамлын төрөл зүйлс өртөх, эсэх | | | Тийм | |
| | **Амьтны аймаг** | | | | |
| | Зэрлэг амьтдын амьдрах орчин доройтуулах, эсэх | | | Тийм | |
| | Ховор, нэн ховор амьтан өртөх эсэх | | | Тийм | |
| Нийгмийн нөлөөллийн урьдчилсан үнэлгээ | **Нутгийн оршин суугчид** | | | | |
| | Газар эзэмших, ашиглах эрх зөрчигдөх эсэх | Тийм | | | |
| | Нутгийн оршин суугчдын нийгмийн байдалд сөрөг нөлөөлтэй, эсэх | | | Тийм | |
| | Нөлөөлөлд өртөж болзошгүй төв суурин газар байгаа эсэх | | | Тийм | |
| | Нүүлгэн шилжүүлэх асуудал үүсэх эсэх | | | Тийм | |
| | **Түүх, соёлын биет өв** | | | | |
| | Сөрөг нөлөөлөлд өртөх түүх соёлын үнэт зүйлс бий эсэх | | | Тийм | |
| | **Хүний эрүүл мэндэд нөлөөлөх нөлөөлөл** | | | | |
| | Нутгийн иргэд, оршин суугчдын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх эсэх | | | Тийм | |
| | Төслийн бүх үе шатанд хүний эрүүл мэнд, амь насанд эрсдэл үүсэх эсэх | | | Тийм | |

**Нэгдсэн дүгнэлт:**

**Улаанбаатар хотын Баянгол дүүргийн 20 дугаар хорооны нутагт хэрэгжүүлж буй "Металл боловсруулах бичил үйлдвэрийн төсөл"-д хийсэн Ерөнхий үнэлгээний гүйцэтгэлээр уг төсөлд холбогдох аргачлалын дагуу Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ /нэмэлт тодотгол/ хийлгэх шаардлагатай гэж үзлээ.**

**Онцгойлон анхаарах зүйлс:**

1. Металл боловсруулах бичил боловсруулах үйлдвэрийн төслийн үйл ажиллагаанд оруулж буй өөрчлөлттэй холбогдуулан хэрэгжүүлэх явцад, уг төслөөс байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг шинэчлэн тодорхойлж, үнэлэлт дүгнэлт өгөх;

2. Үйлдвэрлэл болон бусад дагалдах байгууламжуудад шаардагдах ахуйн болон бусад усны хэрэглээ, ашиглалтыг шинэчлэн тооцож, усны ашиглах боломжит усны нөөцийн талаар эрх бүхий байгууллагаас гаргасан шийдвэрийг тайланд хавсаргаж ирүүлэх;

3. Үйлдвэр болон төслийн бүрэлдэхүүн хэсгээс ялгарах бохирдлын хэмжээ, түүний тархалт, нөлөөллийн хүрээг шинээр тодорхойлж, зураглал үйлдэн тайланд хавсаргах;

4. Төслийн үйл ажиллагааны явцад гарах хатуу, шингэн болон аюултай хог хаягдлыг хүний эрүүл мэнд, байгаль орчинд халгүй аргаар цуглуулах, ангилан ялгах, дахин ашиглах, бүртгэх, шижлүүлэх, устгах, аюулгүй болгох аргыг Хог хаягдлын тухай хуульд нийцүүлэн нарийвчлан тооцож, зөвлөмж өгөх;

5. Төслийн хүрээнд ашиглах химийн бодист эрсдэлийн үнэлгээг төслийн хүчин чадал, баяжуулах технологийн сонголтой уялдуулан шинэчлэн хийлгэж, учирч болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж, тайланд тусгай бүлэг болгон оруулах;

6. Үйл ажиллагааны явцад баримтлах хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны зааварчилгаа, ажиллагсдын эрүүл мэндэд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийн бууруулах зөвлөмжийг хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулах;

7. БОННҮ-д үндэслэн боловсруулсан Байгаль орчны менежментийн төлөвлөгөө /Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр/-г шинэчлэн боловсруулж, түүнийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө, зардлыг 5 жилээр тооцож ирүүлэх;

8. Эцэслэн боловсруулсан БОННҮ-ний ажлын тайланг төсөл хэрэгжих хорооны ИНХ-аар хэлэлцүүлж, хурлын тэмдэглэл, шийдвэрийг тайланд хавсаргах.

**Заавал хэрэгжүүлэх шаардлагатай дээр дурьдсан арга хэмжээг цаг хугацаанд хангаж биелүүлээгүй тохиолдолд өрөнхий үнэлгээний дүгнэлтийг хүчингүй болгож, "Зөрчлийн тухай" хуулийн 7.1 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэгт заасны дагуу хариуцлага тооцдог болохыг анхаарна уу.**

| | |
|---|---|
| Ерөнхий үнэлгээ хийсэн:<br>**БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМНЫ ҮНЭЛГЭЭНИЙ ШИНЖЭЭЧ**<br><br>Гарын үсэг:<br><br>**Д.ШИЖИР-ЭРДЭНЭ** | Ерөнхий үнэлгээний үр дүнг зөвшөөрсөн:<br>**"Талын металл нунтаг" ХХК-ийн гүйцэтгэх захирал**<br><br>Гарын үсэг:<br><br>**Б.Асхар** |

**НИЙСЛЭЛИЙН БАЯНГОЛ ДҮҮРГИЙН
20 ДУГААР ХОРООНЫ ИРГЭДИЙН НИЙТИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ**

2021 оны 12 сарын 17 өдөр Дугаар 10 Улаанбаатар хот

**Байгаль орчинд нөлөөлөх байдлын
үнэлгээний тайлан хэлэлцэх тухай**

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.8, 25 дугаар зүйлийн 25.1, 25.2 дахь хэсэг, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.8 дахь заалтыг тус тус үндэслэн Иргэдийн Нийтийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Тус хорооны хорооны нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа "Талын метал нунтаг" ХХК-ний "Химийн бодис хадгалах, худалдаалах, агуулах" төслийн байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайланг хэлэлцэж дэмжсүгэй.

2. Төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний дагуу байгаль орчныг хамгаалах үнэлгээгээр тогтоогдсон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах урьдчилан сэргийлэхэд анхаарч ажиллах, иргэдийн саналыг харгалзан үзэхийг "Талын метал нунтаг" ХХК-ний удирдлага /Б,Асхар/-д уламжилсугай.

3. Хорооны нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа байгууллага, аж ахуй нэгжийн тохижолт, нийтийг хамарсан их цэвэрлэгээ, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил болон холбогдох хууль тогтоомж, журмын хэрэгжилтийг хангуулж ажиллахыг хорооны Засаг даргын түр орлон гүйцэтгэгч /Д.Сүхбаатар/-д үүрэг болгосугай.

4. Энэхүү тогтоолыг албажуулан зохих байгууллагад ажлын 3 хоногт багтаан хүргүүлэхийг хорооны Иргэдийн Нийтийн Хурлын нарийн бичгийн дарга /Г.Тамирбаатар/-д даалгасугай.

ДАРГА Г.ГАНЧИМЭГ

**НИЙСЛЭЛИЙН БАЯНГОЛ ДҮҮРГИЙН**
**20 ДУГААР ХОРООНЫ ИРГЭДИЙН НИЙТИЙН ХУРЛЫН**
**ТЭМДЭГЛЭЛ**

2021 оны 12 дугаар сарын 17                Дугаар 10/01                Улаанбаатар хот

**Байгаль орчинд нөлөөлөх байдлын**
**үнэлгээний тайлан хэлэлцсэн тухай**

Хурал Баянгол дүүргийн 20 дугаар хорооны иргэний танхимд цахимаар хуралдахаар 2021 оны 12 дугаар сарын 17 ны өдрийн 10 цаг 05 минутанд эхэлж хуралд, Хурлын дарга Г.Ганчимэг, Тэргүүлэгчид Б.Очирхуяг, Ж.Энхмаа, Б.Болд, Б.Доржготов, хорооны Иргэдийн Нийтийн Хурлын нарийн бичгийн дарга Г.Тамирбаатар, "Талын метал нунтаг" ХХК-ийн төлөөлөл, хорооны иргэдийн төлөөлөл иргэн Б.Ганхуяг, Ц.Алтантуул, С.Сувдаа, И.Хэрлэнбаяр, Д.Отгонбаяр нарын ирцтэй эхэлж, хурлын ирц 100-%-тай байв.
ХЭЛЭЛЦСЭН НЬ:

1. "Талын метал нунтаг" ХХК–ний "Химийн бодис худалдаалах, хадгалах, агуулах" төслийн байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний ажлын тайлантай танилцаж үнэлэлт өгөх тухай.

СОНССОН НЬ:

2. Хурлын дарга Г.Ганчимэг:

Өнөөдрийн хурлаар: Тус хорооны нутаг дэвсгэрийн үйлдвэрийн баруун бүсэд үйл ажиллагаа явуулж буй "Талын метал нунтаг" ХХК-ний байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний ажлын тайлангийн талаар хэлэлцье. Та бүхэн "Талын метал нунтаг" ХХК–ийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн төсөл, дэд бүтэц, байгаль орчны үнэлгээ, тоног төхөөрөмж, ажиллагсдын хөдөлмөр хамгааллын нөлөөлөл зэргийг дэлгэрэнгүйгээр байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлангаас үзэж танилцана уу. Уг үнэлгээг "Жемр" ХХК хийж гүйцэтгэсэн.

Тэргүүлэгч Б.Уянга: Төслийн хэрэгжих явцад ашиглагдах химийн бодисын сөрөг нөлөөллийг хэрхэн арилгах вэ

"Талын метал нунтаг"-ХХК-ийн төлөөлөл: Нарийвчилсан үнэлгээний тайланд тусгагдсан зөвлөмжийн дагуу ажиллана.

Иргэн Д.Отгонбаяр: Хорооны нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа учир аж ахуйн нэгжийн нийгмийн хариуцлага талаасаа бас дүүрэг, хороотой хамтран ажиллах, дэмжлэг үзүүлэх талаар саналыг сонсъё.

"Талын метал нунтаг"-ХХК-ийн төлөөлөл: Бид энэ тал дээр хороотой байнга хамтран ажилладаг, төдийгүй үйлдвэрлэлийн төсөл хэрэгжснээр ажлын байруудад, хороотой хамтран ажиллаж хороонд бүртгэлтэй ажилгүй иргэдээс авч ажиллуулахаар төлөвлөж байгаа.

Тэргүүлэгч Б.Очирхуяг: Орон нутгийн байгууллагууд болон тус хорооны Засаг дарга болон Иргэдийн Нийтийн хуралтай харилцан холбоотой ажиллана гэдэгт дэмжиж байна.

Иргэн С.Сувдаа: Төслөөс байгаль орчин тэр дундаа агаарын чанарт ямар нөлөө үзүүлэх вэ?

"Талын метал нунтаг" ХХК-ийн төлөөлөл: Энэхүү төслийн үйл ажиллагааны хүрээнд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй нөлөөллийн байдлыг тогтоохдоо байгаль орчны төлөв байдлын үнэлгээ, дүгнэлтээр газар дээр нь ажилласан үзүүлэх нөлөө байхгүй.

Тэргүүлэгч Б.Доржготов: Үйлчилгээний төвөөс ямар хог хаягдлууд гарах вэ? Яаж устгах вэ?
"Талын метал нунтаг" ХХК-ийн төлөөлөл: Ажиллагсдаас үүсэх болон байгууллагаас ахуйн хог хаягдал гарах, ба энгийн хог хаягдлыг зориулалтын хог хаягдал хадгалах түр цэгт хаяж, ил задгай хаяхгүй хог хаягдлыг шатаахгүй зэрэг арга хэмжээг авч ажиллаж байна.
Захиалгын дагуу нийлүүлэгдэх учраас ямар нэг химийн гаралтай аюултай хог хаягдал гарахгүй.
Иргэн Ц.Алтантуул: үйл ажиллагаатай танилцлаа дэмжиж байна.

Тэргүүлэгч Ж.Энхмаа: Төслийн үйл ажиллагаатай ерөнхийд нь танилцлаа. Уг тайлан дээр байгаль орчныг хамгаалах ажлуудыг төлөвлөгөөнд тусгасны дагуу цаг тухай бүрт хугацаа алдалгүй хийсэн тохиолдолд бидний зүгээс татгалзах зүйлгүй.
Төсөлтэй холбоотойгоор өөр асуулт, хариулт байгаа эсэхийг хуралдаан даргалагч хуралд оролцогчдоос асуухад ямар нэгэн татгалзах санал хүсэлт гараагүй тул "Талын метал нунтаг" ХХК-ийн төсөлтэй танилцаж цаашид уг үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу явуулахыг тус ХХК-ийн гүйцэтгэх захирал /Б.Асхар /-д үүрэг болгов.
"Талын метал нунтаг" ХХК-ийн төслийг дэмжих эсэх талаар санал хураахад хуралд оролцсон тэргүүлэгчид, иргэдийн 100 хувийн саналаар дэмжигдэв.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

3. Нийслэлийн Баянгол дүүргийн 20 дугаар хорооны нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй агуулахыг түрээслэгч "Талын метал нунтаг" ХХК-ийн төслийн, байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайлантай танилцаж цаашид уг үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу явуулахыг дэмжин, хуралд оролцсон иргэдийн Нийтийн Хурлын Тэргүүлэгчид, иргэдийн төлөөллийн саналаар 100% дэмжигдлээ.
Хурал 10 цаг 30 минутанд өндөрлөв.

ТАНИЛЦСАН:
ДАРГА Г.ГАНЧИМЭГ

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН: Г.ТАМИРБААТАР

БАЯНГОЛ ШИНЭ ӨРГӨӨ ОНӨААТҮГ
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Ж.ГАЛТБАЯР

"Талын метал цуглуулах" ХХК
/Иргэн аж ахуйн нэгж/
Гүйцэтгэх захирал П. Асхар

# ХОГ ХАЯГДАЛ ТЭЭВЭРЛЭХ, ХУРААМЖ ТӨВЛӨРҮҮЛЭХ ГЭРЭЭ

20 22 оны 11 сарын 01 өдөр № B/526 Улаанбаатар хот

## Нэг. Ерөнхий зүйл

Энэхүү гэрээ нь "Хог хаягдлын тухай" хууль, Татварын ерөнхий хууль, Баянгол дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид 2017 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 7/04 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангах, Баянгол дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй иргэн, аж ахуйн нэгж, үйлчилгээний газруудаас хог хаягдлын хураамж төвлөрүүлэх, тэдгээрийн үйл ажиллагаанаас бий болсон хог хаягдлыг тээвэрлэхтэй холбогдон гарсан харилцааг зохицуулна.

1.1 Гэрээг

**Нэг талаас:** Баянгол Шинэ Өргөө ОНӨААТҮГ /цаашид тээвэрлэгч гэх/,

**Нөгөө талаас:** ...9011713027... тоот улсын бүртгэлийн, ...6247814... тоот регистрийн дугаартай, Баянгол дүүргийн ...20...-р хорооны нутаг дэвсгэрт ...төмөрлөг боловсруулах... чиглэлээр ...Талын метал цуглуулах... нэртэйгээр үйл ажиллагаа явуулдаг ...П. Асхар... /цаашид хураамж төлөгч гэх/ нар дараах нөхцөлөөр харилцан тохиролцож байгуулав.

## Хоёр. Хог хаягдлын тээвэрлэгчийн эрх, үүрэг

2.1 Хог хаягдлын хураамжийн хэмжээг БГД-ийн ИТХ-ийн тэргүүлэгчдийн **7/04** дүгээр тогтоолд заасан тарифыг мөрдлөг болгон тогтооно;

2.2 Тээвэрлэгч гэрээгээр тохиролцсон хуваарийн дагуу хураамж төлөгчийн **АХУЙН** хог хаягдлын ачиж тээвэрлэнэ;

2.3 Тээвэрлэлт саатсанаас хог хаягдал хуримтлагдсан бол графикт зааснаас бусад цагаар нэмэгдэл хүч зохион байгуулан ачуулах арга хэмжээг авна;

2.4 Хог хаягдлыг тээвэрлэх тусгай зориулалтын, аюулгүй ажиллагааны шаардлагыг хангасан, тээврийн хэрэгсэлтэй байх;

2.5 Хураамж төлөгч тогтоосон хугацаанд хураамж төлөөгүй талаарх мэдэгдлийг Татварын хэлтэс, эрх бүхий албан тушаалтнаас ирүүлсэн тохиолдолд хог хаягдлын тээвэрлэхийг түдгэлзүүлэх, хураамж төлсний дараа тээвэрлэлтийг хэвийн үргэлжлүүлэх, гарсан хохирлыг нэхэмжлэх эрхтэй;

2.6 Хог хаягдлын хураамж төлөхийг шаардах;

3160112053

3.10 Тээвэрлэгчийн доголдолтой үйл ажиллагааны талаарх мэдээллийг хариуцсан албан тушаалтанд тавьж шийдвэрлүүлэх эрхтэй;
3.11 Дүүрэг болон бусад байгууллага, албан тушаалтнаас зарласан уралдаан, аянд идэвхтэй оролцож тодорхой үр дүн үзүүлсэн бол шагнал урамшуулал хүртэх эрхтэй;
3.12 Холбогдох хууль тогтоомжид заасан бусад эрх үүргийг эдэлнэ.

## Дөрөв. Хураамжийн хэмжээ, хураамж төлөлт

4.1 Хог хаягдлын хураамжийн хэмжээ нь БГД-ийн ИТХ Тэргүүлэгчдийн 7/04 дүгээр тогтоолыг үндэслэн сард ..50'000.... улиралд ...150'000...... жилд ...600'000......... төгрөг байна;
4.2 Хог хаягдлын хураамжийг сар бүрийн 15-с 20-ны дотор дүүргийн Татварын хэлтсийн үүссэн нэхэмжлэхийн дугаараар ltax.mta.mn вэб сайтруу хандан төлбөрийн даалгавар үүсгэх цэсийг ашиглан шилжүүлнэ. Татварын лавлах: 1800-1288, БГД-н Татварын хэлтсийн лавлах: 70001288, 21254427;
4.3 Хог хаягдлын хураамжийг гэрээнд заасан хугацаанд бүрэн барагдуулаагүй тохиолдолд татварын өр үүсэхийг анхаарч Татварын хэлтэс болон хариуцсан ажилтны шаардлагыг биелүүлж ажиллана.

## Тав. Гэрээ цуцлах, өөрчлөлт оруулах

5.1 Гэрээнд өөрчлөлт оруулах, хугацаанаас өмнө цуцлах хүсэлтээ 14 хоногийн өмнө хууль эрх зүйн асуудал хариуцсан албан тушаалтанд бичгээр мэдэгдэж үндэслэл, шалтгаанаа тодорхой дурдсан байна;
5.2 Хууль эрх зүйн асуудал хариуцсан албан тушаалтан уг хүсэлтийг хүлээн авч үндэслэл, шалтгааныг нарийн судалж шийдвэрлэх бөгөөд хэрхэн шийдвэрлэсэн тухай хураамж төлөгч талд мэдэгдэнэ.

## Зургаа. Гэрээний хугацаа

6.1 Энэхүү гэрээ нь 20 22 оны 11 сарын 01 -ны өдрөөс 20 24 оны 11 сарын 01 -ны өдөр хүртэл хүчин төгөлдөр үйлчилнэ. Талууд хариуцсан тохиролцож энэхүү гэрээг жил тутам сунгана;
6.2 Гэрээний хугацаа дууссан болович талуудын аль нэг нь гэрээг сунгах эсвэл цуцлах санал гаргаагүй тохиолдолд гэрээг дахин 1 жилээр сунгагдсанд тооцно;
6.3 Гэрээний хугацаа дууссан болович хог хаягдлаа ачуулдаг, үйлчилгээ авдаг ААНБ, иргэний төлөх хураамжийн хэмжээг хэвээр хадгалагдах буюу хүчин төгөлдөр байна.

## Долоо. Хамтран хүлээх хариуцлага

7.1 Талууд энэхүү гэрээг дангаараа гэрээг цуцлах эрхгүй;
7.2 Талууд аливаа маргаан үл ойлголцлыг харилцан тохиролцож шийдвэрлэх бөгөөд шаардлагатай тохиолдолд Шүүхийн журмаар шийдвэрлүүлнэ;
7.3 Нийслэл дүүрэг, эрх бүхий байгууллагаас зохион байгуулсан тусгай болон их цэвэрлэгээний ажилд тээвэрлэгч хамрагдан ажиллах, байгаль цаг уурын онц ноцтой үзэгдэл тохиолдох, хүндэтгэх шалтгаанаар авто зам хаагдсаны улмаас хог ачих боломжгүй болсон, удирдах дээд байгууллагын шийдвэрээр автомашиныг өөр ажилд дайчилсан тохиолдолд хог хаягдал тээвэрлэлтийн хуваарь өөрчлөгдөж